МЭДЭЭ · 2023 оны 3-р сарын 21

ТӨВ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХЭМЖЭЭНД ҮЙЛДЭГДСЭН ЭРҮҮГИЙН БОЛОН ЗӨРЧЛИЙН ХЭРГИЙН ГАРАЛТЫГ СУДАЛЖ, ТАНИЛЦУУЛГА ГАРГАЖЭЭ



ТӨВ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ 2022 ОНД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төв аймгийн прокурорын газраас тус аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2022 онд

үйлдэгдсэн эрүүгийн болон зөрчлийн хэргийн гаралт, шалтгаан нөхцөл, шийдвэрлэлтийн байдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулан судалж, товч танилцуулгыг гаргажээ.

Цаашид судалгааны дүнг орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон аж ахуй нэгж, байгууллага, иргэдэд хүргэж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тодорхой ажлуудыг хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Мөн дээрх судалгааг олон нийтэд хүртээмжтэй, хялбар хүргэх зорилгоор QR код ашиглан үзэж, танилцах боломж нөхцөлийг бүрдүүлсэн нь онцлог ажил болжээ.

Судалгаатай танилцах QR код

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1765